

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026.04.28

Замын-Үүд сум

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 сарын 28-ны өдөр “ БидиСек ҮЦК “ ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах программ болон Zoom программаар онлайнаар 10 цагаас эхлэв.

Тооллогын комисс ирцээ танилцуулав. Тооллогын комиссын гишүүн Э.Пүрэвжаргал ХЭХ-ыг зохион байгуулах системээс ирүүлсэн ирцийн мэдээллийн дагуу гаргасан Тооллогын комиссын ирцийн тогтоолыг уншиж танилцуулав.

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 45,340,290 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцааны 98.14 хувь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, “Э-Транс ложистикс” ХК-ийн Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.14 дэх хэсгийг тус тус үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 98.14 хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга Э.Батболд хурлын дэгийг танилцуулж хурлыг эхлэв.

Хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулав.

Хурлын дэгийн дагуу Компанийн санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг Их монгол хөлөг аудит ХХК-ны аудитор Ариунболд танилцуулав.

Аудитор Ариунболд: Бид Э-Транс ложистикс ХК-ны 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийсэн. Бидний дүгнэлтээр санхүүгийн байдлын тайлан, энэ өрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан өмчийн өөрчлөлтийн тайлан мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлангийн Олон Улсын стандартын дагуу үнэн, шударгаар толилуулсан байна гэж дүгнэж байна. Ингээд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг харъя гэвэл 4-18 дугаар слайдуудад орсон байгаа тэрнээс харж болно. Санхүүгийн тайлангийн хувьд өмнөх оноос нийт хөрөнгө нь 77 сая төгрөгөөр буурсан харагдаж байгаа дансны өр төлбөр өөрчлөлт ороогүй татварын өр 100 гаруй сая төгрөгөөр нэмэгдсэн өр төлбөр нь нийт дүнгээрээ 90 гаруй сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Хурлын дарга Э.Батболд: Ариунтуяад нэмж тайлбарлах тодруулах зүйл байгаа юм уу?

Дэд захирал Э.Ариунтуяа: Хурлын материалд аудитлагдсан тайлангийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй оруулсан. Иймд Компанийн үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирлаас танилцуулах үед санхүүгийн байдлын тайланг тайлбарлаад явчихъя.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал болох компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлагналыг танилцуулахад санхүүгийн тайланг танилцуулах юм байна. Үйл ажиллагааныхаа тайланг танилцуулъя:

Дэд захирал Э.Ариунтуяа: Манай компанийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт дээр гарсан байна. Эргэлтийн хөрөнгийн дүн 3,810,282,529.55 төгрөг, эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн нь 4,598,416,585.54 төгрөг ингээд нийт хөрөнгийн дүн 9,159,398,025.65, богино хугацаат өр төлбөрийн дүн 346,118,219.75, урт хугацаат өр төлбөрийн дүн 2,852,765,504.77, өр төлбөрийн нийт дүн 3,198,883,724.52 ингээд эзэмшигчдийн өмчийн дүн 5,960,514,301.14, өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн мөн балансийн үзүүлэлт буюу 9,159,398,025.65 төгрөг байна. Орлогын тайлангаар борлуулалтын цэвэр орлого маань 2,877,831,532.23, нийт ашиг алдагдал адилхан, Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) 26,894,545.48, байгаа ба нийт орлогын дүн 21,977,312.56 төгрөг байна. Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нийт манай өмч маань 4,620,000,000.13, нэмж төлөгдсөн капитал 154,000,000.00, хуримтлагдсан ашиг маань 411,656,221.01 төгрөг, ингээд өмчийн өөрчлөлтийн тайлангаар нийт 5,960,514,301.14 төгрөг байна. Мөнгөн орлогын дүн 3,277,100,825.14, мөнгөн зарлага 3,216,634,468.91, цэвэр мөнгөн гүйлгээ 60,466,356.23 тэгээд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ маань мөнгөн орлогын дүн 12,247,650.27 мөнгөн зарлагын дүн 1,132,552,526.47, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн хасах 1,120,304,876.20 төгрөг байна. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогын хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 462,114,682.59 төгрөг ингээд үүгээр аудитын тайланг баталгаажуулсан байна.

Гүйцэтгэх захирал Ч.Энхболд: Сайн байцгаана уу. Үйл ажиллагааны хувьд компани ердийн үед үзүүлдэг бүх үйлчилгээгээ хэвийн явуулсан оны сүүлээр ачаалал буурч орлого хумигдсан тал бий. Ер нь бол бид цаашдаа экспортын ачилтыг нэмэгдүүлэх талаар жаахан анхаарч ажиллах төлөвлөгөөг энэ 2026 онд гаргасан. Бусад өрсөлдөгч байгууллагуудаас уул нь илүү өндөр үнэтэй үйлчилгээ үзүүлдэг байсан экспортын хувьд тэрийгээ дахин судалж үзээд бусад үйлчлүүлэгч байгууллагатай адил үнээр өрсөлдөхөөс өөр аргагүй байдалтай гэсэн дүгнэлтэд хүрээд тарифаа бусдад зарлаад экспортоо нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана гэж тооцоолсон. 2025 онд үйл ажиллагаанд онцын өөрчлөлт гарсан зүйлгүй. Чингэлэг тээвэр контейнерийн шилжүүлэн ачилтын тээвэрлэлт буурсан. Өөр ч хэлж ярих зүйл алга байна даа. 2026 онд илүү үр ашигтай ажиллах болов уу гэсэн хүлээлттэй байна.

Ингээд үйл ажиллагааны тайлантай холбоотой асуудал дууссан байна.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал руугаа оръё. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулъя. ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Ганбат танилцуулна.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Ганбат: Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлт гаргасныг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээллээс харвал гаалийн хяналтын бүс дэх үйл ажиллагаа болон үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын үйл ажиллагааны доголдолоос шалтгаалан орлогын байдал нэлээдгүй хэмжээгээр буурсан байдалтай харагдаж байгаа бөгөөд аудитлагдаагүй тайланд татвар дараах ашиг 21,977,312.56 төгрөгийн ашигтай гарсан байна. Ингэж ашиг орлого буурсан шалтгаан нь: 1. Төмөр замаар шилжүүлэн ачилт хийх аж ахуйн нэгжүүд Улаанбаатар төмөр замаар үйлчлүүлэхийг илүүд үздэг болсон / Хятад улсад төмрийн гаалийн татвар нэмэгдсэн үүнээс шалтгаалаад зарим ойролцоох төмрийн үйлдвэрүүд хаагдаж бүүр урдаас Эрээнд вагоноор ирдэг болсон бөгөөд одоо голцуу Цагаан хад боомтоор төмөр орж ирж байгаа цөөн оруулж ирж байгаа нь тариф хямд, вагон олдоцтой гэх шалтгаанаар Улаанбаатар төмөр зам явдаг/, 2. Компанийн гаалийн хяналтын бүсэд өндөрлөсөн тавцан ашиглаж чингэлэг буулгах үйлчилгээ 7 сараас хойш огцом багассан / Олон жилийн насжилттай машинд дугаар олгохгүй болон Улаанбаатар хотын дугаар олгох журам өөрчлөгдсөн, он хуучин машины гаалийн татвар өндөр болсон зэрэг нь энд буулгаж авснаас шууд Улаанбаатар хот руу вагоноор тээвэрлэхэд зардал хямд болсон гэх шалтгаантай/ гэсэн үндсэн 2 асуудлаас болж тухайн жилийн үйл ажиллагаанаас олох орлого өмнөх үеийн мөн үеийнхтэй харьцуулбал нэлээдгүй хэмжээгээр багассан байна. 2024 онд 3823 тээврийн хэрэгсэлд ачигдаж ирсэн чингэлгийг задалж ойролцоогоор 15,200 автомашиныг буулгаж байсан бол 2025 онд 1846 тээврийн хэрэгсэл дэх ойролцоогоор 7755 автомашиныг буулгасан байна ингэснээр тухайн үйл ажиллагаанаас олох орлого бараг 50% буурчээ. Үүний адил төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа өмнөх онд 217 вагон ачаа ачиж байсан бол 2025 онд 14 вагон ачаа ачиж энэ үйл ажиллагаа 93,5 хувь болтлоо буурч 324,435.8 сая. төгрөгний алдагдал хүлээсэн байна. Үндсэн үйл ажиллагаа болон гол орлого олох боломжтой чингэлэг буулгах үйл ажиллагаа буурснаар тухайн үйл ажиллагаануудыг даган орлого нь хэлбэлздэг цайны газар, ГХБ-ийн төлбөр, бусад үйл ажиллагаанаас олох орлогууд мөн адил тодорхой хэмжээгээр буурсан байдалтай байна. Гэхдээ зарим үйл ажиллагаа өмнөх оны мөн үеийн хэмжээнд болон бага зэрэг өссөн байгаа нь ерөнхийдөө тухайн компанийн үйл ажиллагааны доголдол гэхээсээ илүүтэй гадаад хүчин зүйлээс шалтгаалан үйл ажиллагаа тогтворгүй байсантай холбоотой гэж үзэж болно. Тайлангийн тайлан, балансаас харвал өмнөх онд борлуулалтын орлого 3,684,637,955.11 төгрөгт хүрч байсан бол 2025 оны байдлаар 2,877,831,532.23 төгрөг болж 806,806,422.88 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа ба үүнээс гарсан зардлыг харвал борлуулалт, маркетингийн зардал / 2,454,240,164.07 / хамгийн өндөр дүнтэй гарчээ. Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн зарлагын хэсэгт дурьдсанаар гарсан зардлаас хамгийн өндөр дүнтэй нь цалингийн зардал / 1,396,075,326.26 / байх ба Худалдаа хөгжлийн банкнаас авсан зээлийн хүүний төлбөрт 484,390,819.95 төгрөг төлсөн нь

бусад бүх зардлаас их болжээ. Эндээс харвал зээлийн зарцуулалт, төлбөр тооцоонд анхаарлаа хандуулахгүй бол үйлдвэрлэгч биш бусад хүчин зүйлээс хараат компанийн хувьд цаашид зээлийн эргэн төлөлтөнд асуудал гарах нөхцөл байдал үүсэх боломжтой нь харагдаж байна. Гаалийн хяналтын бүс баталгаат агуулах болон төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа нь компанийн хувьд бусдаас хараат үйл ажиллагаа явуулдаг тул үйл ажиллагаагаа тухайн нөхцөл байдалд тохирсон шийдвэрийг шуурхай авч хэрэгжүүлж байж амжилтанд хүрэх тул бизнесийн орчин, тухайн үеийн нөхцөл байдлын мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах төлөвлөлтийг хийж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Гүйцэтгэх удирдлагаас цаашид тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан ажиллах төлөвлөгөөг боловсруулан үйл ажиллагаа явуулж байгаа сум, орон нутгийн эрх барих байгууллага, гаалийн үйл ажиллагаа хариуцсан гаалийн газартай нягт холбоотой ажиллан тэдний тусламж дэмжлэгтэйгээр ажлаа төлөвлөж ажиллах шаардлагатайг энд зориуд дурьдаж байгаа болно. Энэ онд хийж гүйцэтгэхээр хойшлуулсан ажлуудыг буюу гаалийн сүлжээнд холбогдсон ухаалаг хаалт, зогсоолын програмчлал, гадна зогсоолын талбайн хучилт, тохижуулалтын ажлууд, шинээр хяналтын бүсээр зарлуулсан талбайн гэрэлтүүлэг, камерын хяналт, сум орон нутгаас нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэж өгөхийг хүсэн хүсэлт ирүүлээд байгаа ажлуудыг боломжтой байдлаар хийж гүйцэтгэж ажиллахыг мөн зөвлөж байна. За ингээд ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж дууслаа.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг С.Ганбат танилцуулна.

Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан С.Ганбат: 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулъя. 2026 онд нийт 4 бүлэг, 9 хэсэг, 31 ажил хийхээр төлөвлөсөн. Үндсэн ажлын хүрээнд 1.1-т хяналт зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай болон бусад шаардлагатай асуудлаар гүйцэтгэх удирдлагын баг тухай бүр хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргах, Үйл ажиллагаандаа заавал мөрдөж ажиллахаар заагдсан удирдлагын баримт бичгийг ажилчдаас дагаж мөрдөж байгаа байдалд байнгын хяналт тавьж ажиллах, Компанийн ажилчид ажил үүргээ гүйцэтгэхдээ холбогдох дүрэм, журам, ажлын цаг ашиглалт зөрчиж байгаа эсэхэд дотоод хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулах, Ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээг үр дүнтэй, чанартай хийж гүйцэтгэх талаар заавар зөвлөгөө өгч ажиллах, Ажилчид болон гүйцэтгэх удирдлагын баг нь өөрийн үйл ажиллагаа, харилцааны асуудалд онцгой анхаарч ажиллах ба Компанийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах ажлыг төлөвлөж гүйцэтгэх удирдлагаас хийж гүйцэтгэхээр заажээ. 1.2-т Вагон ачилтыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд Төмөр замтай байгуулах гэрээ, хэлцлүүдийг байгуулах, хугацаа дуусмагц сунгах, гэрээний дүнг хэлэлцэх, Төмөр замаар шилжүүлэн ачих ажлыг нэмэгдүүлэхэд анхааран үйлчлүүлэгч нартай уулзалт зохион байгуулах ажлыг Ачаа тээврийн алба зохион байгуулахаар төлөвлөсөн. 1.3 Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын өнгө үзэмж, эмх цэгцийг байнга шалгаж шаардлагатай ажлуудыг танилцуулан хийж ажиллах, Гаалийн баталгаат агуулахыг шинэчлэн засварлахтай холбоотой хийгдэх ажлыг

төлөвлөн удирдлагад танилцуулах, Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн, баталгаат агуулахад хадгалагдаж байгаа тээврийн хэрэгсэл, ачаа барааны тайланг сар, улирал, жилээр гарган холбогдох газар, компанийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж байх, Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын харуул хамгаалалтын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж үүрэг чиглэл өгч ажиллах, Хяналтын бүсийн зам талбайг засварлах тэгшлэх, ус тогтоохгүй байх ажил зохион байгуулах ажлыг Гаалийн хяналтын бүс хариуцсан менежер Б.Золжаргалд хариуцуулан хийхээр төлөвлөсөн. 1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах, ажилтны аюулгүй ажиллах нөхцлийг хангах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалтыг улирал бүр зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас сургагч багш урьж авчран ажилчдыг сургалтанд хамруулж байх, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгыг тогтоосон хугацаанд өгч өгсөн зааварчилгыг ажилтны хувийн хэрэгт хавсаргаж байх, Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эдэлгээний норм хугацаа дууссан эсэхийг ажилтан нэг бүрийхийг үзэн шалган гүйцэтгэх удирдлагад танилцуулан шаардлагатай хувцас хэрэгслийг нөхөж авах, хувцас хэрэгслийг картлан ажилтанд тавьж олгох, Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дүрэм журам зөрчигдөж байгаа эсэхэд байнгын үзлэг шалгалт зохион байгуулах, Аюулыг мэдэгдэх хуудасны ашиглалтыг нэмэгдүүлэх, ажилтан бүрт энэ талаар үүрэг даалгаврыг ХАБЭАхуйн зааварчилгын хамт өгөх гэсэн ажлуудыг ХАБЭА асуудал хариуцсан ажилтан Ж.Сайнжаргалд хариуцуулсан байна. 2. Дотоод ажлын хүрээнд 2 салбар ажил хийхээр төлөвлөсөн. 2.1 Засвар үйлчилгээ, тохижолтын ажлын хүрээнд Оффисын болон баталгаат агуулахуудын дээврийн будаг болон зарим тохижолтын ажлыг хийж гүйцэтгэх, Оффисын үүдний машины ил зогсоолын талбайг асфальтлах, түүнийг тойрсон хашаа, орох гарах хэсэг дэх хаалтууд, гэрэлтүүлэг, хяналтын камер суурьлуулах ажлыг хийх, Машин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн үзлэг, тооллогод хамруулах, Өдөр тутам болон байнга хийгдэх засвар, үйлчилгээний ажлуудыг тогтоосон цагт, өгсөн нарядын дагуу хийж байгаад байнгын хяналт тавьж ажиллах ажлыг Механик цех, гүйцэтгэх удирдлагад хариуцуулсан байна. 2.2. Техник технологийн шинэчлэлтийн хүрээнд Сургалт соён гэгээрүүлэх ажил, Нийгмийн хамгаалалын чиглэлээр Ажилтан нарт шаардлагатай сэдвүүдийн дагуу бусад байгууллагуудаас сургагч урьж сургалт явуулах, Ажилчдын эв нэгдлийг хангах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж тодорхой төрлийн урлаг спортын арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулах, Ажилчдыг компанид тогтвор суурьшилтай, идэвхитэй ажиллахад нөлөөлөхүйц компанийн дотоод журамд заагдсан нийгмийн хамгаалалын тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх, Шинээр хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын хүрээнд хийгдэх ногоон байгууламжийн ажлуудыг хийж гүйцэтгэх, Үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран нийгмийн хамгаалалын тодорхой ажлыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах комисс болон гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад хариуцуулсан байна. 4. Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хурал гэсэн асуудлын хүрээнд Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, зөвлөлийн дэргэдэх хорооны хуралд бэлтгэх, гишүүдэд шаардлагатай мэдээллүүдийг цаг тухай бүрт хүргэх, Компанийн жилийн ба хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг бусад албадаас ирүүлсэн саналын дагуу гаргаж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, Компанийн засаглалын

бодлогыг хэрэгжүүлж нийтэд ил болгох мэдээллүүдийг компанийн албан ёсны вэб хуудас, хөрөнгийн бирж, компанийн засаглалын сайтуудад тухай бүр тавьж хувьцаа эзэмшигч нарыг компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр бүрэн хангах, Хувьцаа эзэмшигчдийн хуралд шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь бэлэн болгох, хурал хуралдах ажлыг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэгч компанитай хамтран зохион байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ганбатад хариуцуулахаар төлөвлөсөн байна. Төлөвлөгөөг танилцуулж дууслаа.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал руугаа оръё. ТУЗ-ийн 2026 оны цалин урамшууллын төсвийг хурлын нарийн бичгийн дарга танилцуулна.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Ганбат: ТУЗ-ийн гишүүд цалингүй ажиллаж байгаа. ТУЗ-ийн нарийн бичгийн цалин 792,000 төгрөгөөр 4 улиралд 3,168,000 төгрөг, Зөвлөх үйлчилгээний хөлс 3,500,00 төгрөг, ТУЗ-ийн хурлын зардал 100,000 төгрөг, бичиг хэргийн зардал 700,000 төгрөг, Бусад зардал 300,000 төгрөг гээд нийт 7,768,000 төгрөгийн зардал гаргахаар төсөвлөсөн байна.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудал ТУЗ-д нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга танилцуулна.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Ганбат: Эдгээр нэр дэвшигч нар улирч сонгогдож байгаа хүмүүс байгаа юм. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Чулууны Энхболд, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Энхболдын Батболд, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Энхболдын Уянга, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Амарсанаагийн Бат-Орших, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Эрдэнэбаатарын Ариунтуяа, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Амарсанаагийн Гэрэлцогт нар нэр дэвшиж байна. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа хүмүүс хэвээрээ 2025 оноос улирч нэр дэвшиж байгаа. Шинээр нэр дэвшиж байгаа ТУЗ-ын хараат бус гишүүнээр Баярхүүгийн Оюунтуяа, 1978 онд төрсөн Мэйджор Саплай ХХК-ны Захиргаа хүний нөөцийн албаны дарга ажилтай, боловсролын байдал нь 33-р дунд сургууль, Оточ Манрамба Анагаах ухааны дээд сургуульд хүний их эмч бакалавр, Шинжлэх ухаан техникийн их сургуулийн БУХС-д бизнесийн удирдлага-Хүний нөөцийн менежмент магистр, 2020 онд тус сургуульдаа Бизнесийн удирдлага-Хүний нөөцийн менежмент доктарантаар сурч байгаа. Эрхэлж байсан ажлын хувьд Хосцэцэг ХХК-нд Гүйцэтгэх захирал, СодМонгол Групп ХХК-нд Хүний нөөцийн менежер, УБ БҮК ХК-нд Хүний нөөцийн албаны дарга, Гоёл кашмер ХХК-нд Захиргаа хүний нөөцийн хэлтсийн захирал, 2023 оноос Мэйджер Саплай ХХК-нд Захиргаа хүний нөөцийн хэлтсийн даргаар ажиллаж байгаа эмэгтэй шинээр нэр дэвшиж байна. 2-р Чулуунбаатарын Оргил, Жаргалсайханы Энхтулга нар өмнө нь ажиллаж байгаад дахиж өөрийгөө нэр дэвшүүлж байгаа.

Хурлын дарга Э.Батболд: Дараагийн асуудлыг танилцуулая. Энэ асуудлыг би уншаад танилцуулчихъя. Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 3-р зүйлийн 3.19.9 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эцнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн тогтоох нь: 1. “ Э-Транс Логистикс ” ХК-ны 2025 оны санхүүгийн

нөхцөл байдал ногдол ашиг тараах хэмжээнд байгаагүй тул тухайн оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай. 2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал Ч. Энхболдод үүрэг болгосугай. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Батболд гэсэн тогтоолыг танилцуулж байна. За ингээд өнөөдрийн хурлаар хэлэлцэх, танилцуулах асуудал дуусаж байна. Ингээд оролцогчдийн зүгээс асууж тодруулах зүйлтэй хүмүүс байгаа бил үү? Асуух зүйл байхгүй бол саналын хуудас бөглөх зааврыг тооллогын комисс өгөх үү.

Тооллогын комиссын гишүүн Э.Пүрэвжаргал: Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар маань agm.mn гээд хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах сайтаар нэвтэрч орсон байгаа. Та бүхэн хурлын ирцийн доор харагдаж байгаа хэсгийн доор санал өгөх гэсэн товч байгаа тэрэн дээр дараад хурлын хэлэлцэж буй 6 санал хураах асуултаар зөвшөөрсөн татгалзсан түдгэлзсэн гэдэг сонголтуудаас аль нэгийг сонгоод үргэлжлүүлэх товчийг дарах юм бол 6 дахь асуудал буюу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох гэсэн хэсэг гарч ирнэ. Та бүхэн маань кумулятив саналын аргаар 9 гишүүнд өөрийн кумулятив саналын эрхээ хуваан өгөх боломжтой. Кумулятив саналын эрхээ бүрэн хувааж өгснөөр саналын хуудас хүчинтэй тооцогдоно. Та бүхэн бүрэн өгсөн тохиолдолд санал өгөх товчийг дарж баталгаажуулснаар таны санал системд бүртгэгдэнэ.

Хурлын дарга Э.Батболд: За та бүхэн санал хураах заавартайгаа танилцаж дууссан бол саналаа хураая. 15 минутанд санал өгч амжих байх. Тооллогын комисс шийдвэрээ танилцуулах уу.

Тооллогын комиссын гишүүн Э.Пүрэвжаргал: Тооллогын комисс маань саналыг нэгтгэж дууслаа шийдвэрийг танилцуулъя. Э-Транс ложистикс хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэр 2026 оны 4 сарын 28-ны өдөр дугаар №02 Улаанбаатар хот. Э-Транс ложистикс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн шийдвэрлэх нь: Э-Транс ложистикс ХК-ийн саналын эрхтэй нийт 46,200,000 ширхэг хувьцаанаас 98,14 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0% хувь түдгэлзсэн байна.

2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0% хувь түдгэлзсэн байна.

3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай

2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0% хувь түдгэлзсэн байна.

4. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0% хувь түдгэлзсэн байна.

5. ТУЗ-ийн 2026 оны цалин урамшууллын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувь зөвшөөрсөн, 0% хувь татгалзсан, 0% хувь түдгэлзсэн байна.

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бүс гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувь буюу 45,340,292 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Чулууны Энхболд	11.11%	45,340,292
2	Амарсанаагийн Бат-Орших	11.11%	45,340,292
3	Энхболдын Батболд	11.11%	45,340,292
4	Эрдэнэбаатарын Ариунтуяа	11.11%	45,340,292
5	Энхболдын Уянга	11.11%	45,340,292
6	Амарсанаагийн Гэрэлцогт	11.11%	45,340,292

Хараат бүс гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Жаргалсайханы Энхтулга	11.11%	45,340,292
2	Баярхүүгийн Оюунтуяа	11.11%	45,340,292
3	Чулуунбаатарын Оргил	11.11%	45,340,292

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов. За тооллогын комиссын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулж дууслаа.

Хурлын дарга Э.Батболд: За хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Хурлын нарийн бичиг уншаад танилцуулчих.

ТУЗ-ын нарийн бичгийн дарга С.Ганбат: Хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулсан бөгөөд хэлэлцэх асуудал болон санал хураалттай холбоотой ямар нэгэн санал гомдол гараагүй тул 11:05 цагт хурлыг хаав.

Хурлын дарга:

Э.Батболд /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

С.Ганбат /

